



**ЭМЭЭЛТИЙН ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН  
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ**

2016 оны 02 сарын 01 өдөр

Дугаар Б/15

Улаанбаатар хот

Г Э.Энхтүвшинг ажилд томилох тухай Г

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.2, 16.5.3, Нийслэлийн Засаг даргын 2014 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн “Эмээлтийн Хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын бүтэц орон тоог батлах тухай” А/1046 тоот захирамж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 149 дүгээр тогтоолын хавсралт “Эмээлтийн Хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.5, 5.1.8, “Эмээлтийн Хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын даргын 2016 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн “Зохион байгуулалтын бүтэц шинэчлэн батлах тухай” А/01 дугаар тушаал, Сонгон шалгаруулах комиссын 2016 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрдэнэбаяр овогтой Энхтүвшинг тус газрын Төсөл хэрэгжүүлэх хэлтсийн Хөнгөн үйлдвэрийн технологич инженерээр 2016 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн томилсугай.

2. Э.Энхтүвшиний үндсэн цалинг албан тушаалын 1-1 дугаар шатлалын 633,221 /зургаан зуун гучин гурван мянга хоёр зуун хорин нэг/ төгрөг, ажилласан хоног тутамд унаа, хоолны хөнгөлөлтийг 3100 төгрөгөөр тооцож олгохыг Нягтлан бодогч Г.Батнямд зөвшөөрсүгэй.

3. Э.Энхтүвшиний ажлыг зохих журмын дагуу хүлээлцүүлэхийг Захиргаа, санхүү төлөвлөлтийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн Б.Алтан-Очирт даалгасугай.

ДАРГА  М.ГОНЧИГЖАВ



3150600024